

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 3 дугаар сарын 26-ны өдөр

№ 19/23

Улаанбаатар хот

Компанийн хувьцаа халааслах ажиллагааг зохион байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.12, 62.1.15 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.14, 9.6.15 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн ээлжит хурлын 05 тоот тогтоолыг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. ЛэндМН ББСБ ХК-ийн 2019 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 05 тоот тогтоолыг үндэслэн гүйцэтгэх удирдлага болон ажилчдын дунд хугацааны урамшууллын бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Компанийн нийт гаргасан хувьцааны 0.5 (тэг бүхэл аравны тав) хувь буюу 4,000,000 (дөрвөн сая) ширхэг хувьцааг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл хугацаанд, тухайн үеийн зах зээлийн ханшаар эргүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны дарга (В.Баярсайхан)-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД



..... /О.БОЛДБААТАР/ /Б.ДЭЛГЭРЖАРГАЛ/

..... /В.БАЯРСАЙХАН/ /Н.ЦЭВЭГМИД/

..... /С.ЭНХ-АМГАЛАН/ /Ж.ЖАРГАЛСҮРЭН/

..... /С.БОРГИЛ/ /Ч.НОМИН/

..... /МЭТЬЮ ВЭЛЧ/